



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2005 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 01/33

Улаанбаатар хот

Г Хүн амын амьжиргааны доод түвшинг Г  
батлах тухай

“Статистикийн тухай” Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” Монгол улсын хуулийн 5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Холбогдох аргачлалын дагуу тооцсон “Хүн амын амьжиргааны доод түвшин”-гийн 2005 онд мөрдөх хэмжээг хавсралтад дурдсанаар баталсугай.

Хоёр. Шинэчлэн тогтоосон “Хүн амын амьжиргааны доод түвшин”-гийн талаар холбогдох байгууллагад танилцуулж, нийтэд мэдээлэхийг Статистикийн төлөвлөлт, Бодлого Зохицуулалтын Газар (А.Дэмбэрэл)-т даалгасугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хүн амын амьжиргааны доод түвшинг батлах тухай” Үндэсний статистикийн газрын даргын 2004 оны 48 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П. БЯМБАЦЭРЭН

УСГ-ын даргын 2005 оны 3-р сарын 28-ны  
өдрийн 01/24 тоот тушаалын хавсралт

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төгрөгөөр
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	23200
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	22600
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	22300
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	25000
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	30000